



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2000 оны 03 дугаар
сарын 08 ны өдөр

№22

Улаанбаатар
хот

“Хо Цэ Тэ” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2-ын 4 дэх заалт, Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1999 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 04 тоот тогтоол, Багануур дүүргийн Засаг даргын хүсэлтийг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Нийслэлийн Багануур дүүргийн Хот тохижилт, нийтийн үйлчилгээний “Хо Цэ Тэ” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2000 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

2. “Хо Цэ Тэ” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын нийт хөрөнгийг ажиллагсдын хамт Багануур дүүргийн “Авто жим” нийслэлийн өмчит үйлдвэрийн газарт нэгтгэн зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдод үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮ-
ЛЭГЧДИЙН ДАРГА *Ц.Баасанжав*

Ц.БААСАНЖАВ

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Г.Маналжав*

Г.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

Т.Билэгт
Т.БИЛЭГТ
Э.ГОМБОЖАВ
С.МӨНХЖАРГАЛ
Б.НАМХАЙНЯМБУУ
Р.ӨЛЗИЙ
С.ПҮРЭВ
Ш.ТҮВДЭНДОРЖ